

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/72/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.22 № 9/145  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/03 тушаалаар бүтэц орон тоо 25 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 44 арга хэмжээтэй баталснаас нийт 95,6 %-тай дүгнэгдсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Мөнгөнморьт түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1,083,819.7 мянган төгрөг, орон нутгийн хөгжийн сангийн хөрөнгөөр 473,663.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.
- Тайлант онд авлага дансны эцсийн үлдэгдэл 33,744.0 мянган төгрөгөөр буюу НДШ-ийн авлага 2,486.5 мянган төгрөг, ЗДТГ-ын тракторын агрегатын эхний төлбөр шилжүүлснээс нэмэгдсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,526,622.92</b>	<b>138,850,892.68</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>0</b>	<b>33,743,984.16</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>33,743,984.16</b>
33510	Байгууллагаас авах авлага	0	31,257,484.16
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	2,486,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>71,526,622.92</b>	<b>105,106,908.52</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>440,000.00</b>	<b>0</b>
35130	Эм боох материал	440,000.00	0
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>58,586,622.92</b>	<b>92,606,908.52</b>
35410	Бичиг хэргийн материал	4,451,000.00	4,943,200.00
35420	Аж ахуйн материал	42,758,752.52	61,248,752.52
35430	Сэлбэг хэрэгсэл	850,000.00	0
35440	Түлш, шатах тослох материал	1,895,670.40	0
35460	Хүнсний материал	0	1,002,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,631,200.00	25,412,956.00
35600	Мал амьтад	12,500,000.00	12,500,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,804,592,879.09</b>	<b>3,998,015,530.13</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,804,592,879.09</b>	<b>3,998,015,530.13</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,763,265,546.05</b>	<b>3,898,664,863.43</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,294,969,965.00	1,452,286,492.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-298,696,330.18	-360,911,618.02
39203	Авто-тээврийн хэрэгсэл	701,045,123.00	899,045,123.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-258,939,561.96	-329,926,708.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	167,829,314.20	231,528,404.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-110,125,044.19	-136,103,079.99
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,550,643.72	118,320,643.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-63,110,120.12	-76,107,907.54
39209	Зам, гүүрийн байгууламж	761,422,696.00	789,160,996.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-110,054,580.72	-140,838,804.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,009,809,222.96	1,966,408,030.96
39215	Хуримтлагдсан элэгдэл	-433,546,381.66	-560,781,407.92
39216	Дуусаагүй барилга, байгууламж	15,110,600.00	43,035,600.00
39217	Ном	0	3,549,100.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>41,327,333.04</b>	<b>99,350,666.70</b>
39301	Програм хангамж	3,780,000.00	5,530,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,356,666.96	-3,592,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	40,904,000.00	131,589,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0	-34,175,833.30
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,876,119,502.01</b>	<b>4,136,866,422.81</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,653,089.92</b>	<b>4,000,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>4,653,089.92</b>	<b>4,000,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>4,653,089.92</b>	<b>4,000,000.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	42,489.92	0
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>4,610,600.00</b>	<b>4,000,000.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	4,610,600.00	4,000,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,871,466,412.09</b>	<b>4,132,866,422.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,871,466,412.09</b>	<b>4,132,866,422.81</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	667,794,348.38	667,794,348.38
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	667,794,348.38	667,794,348.38
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,002,663,269.03</b>	<b>3,264,063,279.76</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,607,152,099.59	2,002,663,269.04
51220	Тайлант үеийн үр дүн	395,511,169.44	1,261,400,010.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,008,794.68	201,008,794.67
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,876,119,502.01</b>	<b>4,136,866,422.81</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

				/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН		
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,794,093,091.80</b>	<b>2,612,713,653.80</b>		
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>702,857,853.00</b>	<b>286,560,000.00</b>		
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>702,857,853.00</b>	<b>286,560,000.00</b>		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	697,407,853.00	267,674,000.00		
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,450,000.00	18,886,000.00		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,091,235,238.80</b>	<b>2,326,153,653.80</b>		
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>75,185,838.80</b>	<b>315,364,053.80</b>		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,105,536.00	238,271,630.00		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,080,302.80	77,092,423.80		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,016,049,400.00</b>	<b>2,010,789,600.00</b>		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,016,049,400.00	2,010,789,600.00		
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,398,082,522.52</b>	<b>1,351,313,643.08</b>		
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>833,436,965.52</b>	<b>1,262,505,340.48</b>		
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>686,565,200.49</b>	<b>1,018,938,399.54</b>		
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>223,137,468.43</b>	<b>389,220,260.84</b>		
210101	Үндсэн цалин	94,599,054.91	295,602,432.37		
210102	Нэмэгдэл	14,381,197.57	79,999,374.51		
210104	Урамшуулал	3,639,957.40	13,618,453.96		
210105	Гэрээт ажлын хөлс	110,517,258.55	0		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,210,873.09</b>	<b>48,649,900.07</b>		
210201	Тэтгэврийн даатгал	19,515,612.64	33,646,954.09		
210202	Тэтгэмжийн даатгал	2,291,012.73	3,958,757.44		
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,812,649.68	3,149,406.12		
210204	Ажилгүйдлийн даатгал	402,011.17	682,278.72		
210205	Эрүүл мэндийн даатгал	4,189,586.87	7,212,503.70		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>72,302,677.94</b>	<b>74,431,732.27</b>		
210301	Гэрэл, цахилгаан	11,537,392.54	12,284,662.27		
210302	Түлш, халаалт	51,442,629.00	54,717,870.00		
210303	Цэвэр, бохир ус	9,322,656.40	7,429,200.00		
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>52,744,027.70</b>	<b>57,208,158.40</b>		
210401	Бичиг хэрэг	10,579,300.00	3,678,820.00		
210402	Тээвэр, шатахуун	34,766,747.50	52,229,288.40		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,316.00	860,050.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,797,664.20	440,000.00		
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0</b>	<b>4,293,000.00</b>		
210604	Урсгал засвар	0	4,293,000.00		
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	<b>3,315,000.00</b>	<b>6,525,892.00</b>		
210702	Дотоод албан томиллолт	3,315,000.00	6,525,892.00		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,350,369.00</b>	<b>4,137,018.00</b>		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,787,200.00	2,925,414.00		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,000.00	0		
210803	Даатгалын үйлчилгээ	377,475.00	533,050.00		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,694.00	414,554.00		
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	264,000.00		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>302,504,784.33</b>	<b>434,472,437.96</b>		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,401,539.63	69,863,264.00		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	254,103,244.70	364,609,173.96		
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>146,871,765.03</b>	<b>243,566,940.94</b>		
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,026,100.00</b>	<b>25,390,600.00</b>		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,686,200.00	0		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,339,900.00	25,390,600.00		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>106,845,665.03</b>	<b>218,176,340.94</b>		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,061,966.23	218,176,340.94		
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	31,783,698.80	0		
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>564,645,557.00</b>	<b>88,808,302.60</b>		
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>564,645,557.00</b>	<b>88,808,302.60</b>		
221001	Их засвар	564,645,557.00	88,808,302.60		
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>396,010,569.28</b>	<b>1,261,400,010.72</b>		
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>499,399.84</b>	<b>0</b>		
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	499,399.84	0		
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>395,511,169.44</b>	<b>1,261,400,010.72</b>		

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,091,235,238.80</b>	<b>2,326,153,653.80</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,091,235,238.80</b>	<b>2,326,153,653.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>75,185,838.80</b>	<b>315,364,053.80</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,105,536.00	238,271,630.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,080,302.80	77,092,423.80
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,016,049,400.00</b>	<b>2,010,789,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,016,049,400.00	2,010,789,600.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>593,744,971.80</b>	<b>1,678,131,687.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>593,744,971.80</b>	<b>1,678,131,687.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>446,873,206.77</b>	<b>1,434,564,746.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>201,127,464.65</b>	<b>389,262,750.76</b>
210101	Үндсэн цалин	157,349,546.13	295,602,432.37
210102	Нэмэгдэл	33,433,110.69	79,999,374.51
210104	Урамшуулал	3,248,052.40	13,660,943.88
210105	Гэрээт ажлын хөлс	7,096,755.43	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>24,659,788.72</b>	<b>48,652,384.23</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,127,438.29	33,649,438.25
210202	Тэтгэмжийн даатгал	1,985,659.48	3,958,757.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,558,707.92	3,149,406.12
210204	Ажилгүйдлийн даатгал	362,856.60	682,278.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,625,126.43	7,212,503.70
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>76,004,935.54</b>	<b>76,996,457.27</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,537,392.54	12,284,662.27
210302	Түлш, халаалт	51,442,629.00	53,457,870.00
210303	Цэвэр, бохир ус	13,024,914.00	11,253,925.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,822,016.00</b>	<b>35,156,703.00</b>
210401	Бичиг хэрэг	2,224,400.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,797,300.00	28,863,733.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,600,316.00	1,292,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,500,000.00</b>	<b>4,513,000.00</b>
210604	Урсгал засвар	1,500,000.00	4,513,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,755,000.00</b>	<b>5,295,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,755,000.00	5,295,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,983,309.00</b>	<b>11,024,518.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,420,140.00	9,812,914.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	377,475.00	533,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,694.00	414,554.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	165,000.00	264,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>81,020,692.86</b>	<b>863,663,933.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,020,692.86	863,663,933.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>146,871,765.03</b>	<b>243,566,940.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,026,100.00</b>	<b>25,390,600.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,686,200.00	25,390,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,339,900.00	0
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>106,845,665.03</b>	<b>218,176,340.94</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	75,061,966.23	218,176,340.94
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	31,783,698.80	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>497,490,267.00</b>	<b>648,021,966.60</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>497,490,267.00</b>	<b>648,021,966.60</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>497,490,267.00</b>	<b>648,021,966.60</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>497,490,267.00</b>	<b>648,021,966.60</b>
220001	Барилга байгууламж	119,815,600.00	236,109,664.00
221001	Их засвар	120,000,000.00	0
222001	Тоног төхөөрөмж	0	15,000,000.00
223001	Бусад хөрөнгө	34,122,577.00	214,062,602.60
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	223,552,090.00	182,849,700.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-497,490,267.00</b>	<b>-648,021,966.60</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	667,794,348.38	202,477,303.04	1,137,236,649.32	00.00	2,007,508,300.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>667,794,348.38</b>	<b>202,477,303.04</b>	<b>1,137,236,649.32</b>	<b>00.00</b>	<b>2,007,508,300.74</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	183,798,881.28	00.00	183,798,881.28
C08	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>667,794,348.38</b>	<b>201,008,794.67</b>	<b>2,002,663,269.04</b>	<b>00.00</b>	<b>2,871,466,412.09</b>
D01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>667,794,348.38</b>	<b>201,008,794.67</b>	<b>2,002,663,269.04</b>	<b>00.00</b>	<b>2,871,466,412.09</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>667,794,348.38</b>	<b>201,008,794.67</b>	<b>2,002,663,269.04</b>	<b>00.00</b>	<b>2,871,466,412.09</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,261,400,010.72	00.00	1,261,400,010.72
D09	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>667,794,348.38</b>	<b>201,008,794.67</b>	<b>3,264,063,279.76</b>	<b>00.00</b>	<b>4,132,866,422.81</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,010,789,600.00</b>	<b>1,825,878,501.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,467,405,000.00</b>	<b>1,360,706,235.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,442,014,400.00</b>	<b>1,335,315,635.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>378,093,400.00</b>	<b>376,933,317.36</b>
210101	Үндсэн цалин	329,285,300.00	285,779,383.34
210102	Нэмэгдэл	48,808,100.00	77,492,990.14
210104	Урамшуулал	0	13,660,943.88
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>47,261,600.00</b>	<b>47,138,607.48</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,137,900.00	32,596,854.86
210202	Тэтгэмжийн даатгал	3,780,900.00	3,834,924.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,024,700.00	3,050,339.45
210204	Ажилгүйдлийн даатгал	756,200.00	660,852.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7,561,900.00	6,995,637.02
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>76,286,000.00</b>	<b>65,992,432.27</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,151,600.00	12,284,662.27
210302	Түлш, халаалт	60,884,500.00	53,457,870.00
210303	Цэвэр, бохир ус	249,900.00	249,900.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,471,700.00</b>	<b>23,964,670.00</b>
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,671,700.00	17,671,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,800,000.00	1,292,970.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	3,000,000.00	3,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,300,000.00</b>	<b>4,293,000.00</b>
210604	Урсгал засвар	4,300,000.00	4,293,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,295,400.00</b>	<b>5,295,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,295,400.00	5,295,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,583,800.00</b>	<b>10,297,728.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,500,000.00	9,086,124.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	533,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,700.00	414,554.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	416,700.00	264,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>889,722,500.00</b>	<b>801,400,880.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	889,722,500.00	801,400,880.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,390,600.00</b>	<b>25,390,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,390,600.00</b>	<b>25,390,600.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,390,600.00	25,390,600.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>543,384,600.00</b>	<b>465,172,266.60</b>
220001	Барилга байгууламж	269,045,100.00	236,109,664.00
221001	Их засвар	4,610,600.00	0
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	15,000,000.00
223001	Бусад хөрөнгө	254,728,900.00	214,062,602.60
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,010,789,600.00</b>	<b>2,010,789,600.00</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,482,405,000.00</b>	<b>2,010,789,600.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,482,405,000.00	2,010,789,600.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>528,384,600.00</b>	<b>0</b>
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	528,384,600.00	0
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>47</b>	<b>47</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>23</b>	<b>23</b>
620001	Удирдах ажилтан	6	6
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>23</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>43,402,140.00</b>	<b>282,198,811.15</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>43,402,140.00</b>	<b>282,198,811.15</b>
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>38,062,040.00</b>	<b>282,198,811.15</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	12,329,433.40
210101	Үндсэн цалин	-	9,823,049.03
210102	Нэмэгдэл	-	2,506,384.37
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	<b>1,513,776.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	-	1,052,583.39
210202	Тэтгэмжийн даатгал	-	123,833.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	99,066.67
210204	Ажилгүйдлийн даатгал	-	21,426.67
210205	Эрүүл мэндийн даатгал	-	216,866.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>12,654,077.00</b>	<b>11,104,025.00</b>
210303	Цэвэр, бохир ус	12,654,077.00	11,104,025.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,878,300.00</b>	<b>11,192,033.00</b>
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	777,600.00	11,192,033.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,700.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	220,000.00
210604	Урсгал засвар	-	<b>220,000.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	-	726,790.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	726,790.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,529,663.00</b>	<b>245,112,753.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,529,663.00	245,112,753.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,340,100.00</b>	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,340,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,340,100.00	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>75,185,838.80</b>	<b>315,364,053.80</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>75,185,838.80</b>	<b>315,364,053.80</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,830,816.00	238,271,630.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,355,022.80	77,092,423.80

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар нь “Төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/03 тушаалаар бүтэц орон тоо 25 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 44 арга хэмжээтэй баталснаас нийт 95,6 %-тай дүгнэгдсэн байна.

Тайлант онд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар сумын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажил 91,500.0 мянган төгрөг, айл өрх, үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн дулаанд холбох ажил 79,954.0 мянган төгрөг, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар ЗДТГ-ын авто машины парк шинэчлэл, усны болон хог тээвэрлэх машин 178,000.0 мянган төгрөг, сумын төвийн хөрсний бохирдол бууруулах зорилгоор 11 байрлалд 54 кабин бүхий эко нойл 282,000.0 мянган төгрөг, сумын төвийн хуучин хогийн цэгийг дарж булж, шинээр 100х50 хэмжээтэй шинэ хогийн цэгийг 57,000.0 мянган төгрөгөөр тус тус бүтээн байгуулалтыг хийсэн байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17, мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Мөнгөнморьт түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/15 тушаалаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар жилийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, тухай бүр удирдамж гарган дотоод хяналт шалгалтыг хийж хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 2021-2022 онуудын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/22 тоот захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,260,746.9 мянган төгрөгөөр буюу 50,1 хувиар нэмэгдсэн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>Б</b>	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	-	33,744.0	33,744.0
Урьдчилгаа	-		
Бараа материал	71,526.6	105,106.9	33,580.3
Үндсэн хөрөнгө	2,804,592.9	3,998,015.5	1,193,422.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,876,119.5</b>	<b>4,136,866.4</b>	<b>1,260,746.9</b>
Өр төлбөр	4,653.1	4,000.0	(653.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,871,466.4	4,132,866.4	1,261,400.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,876,119.5</b>	<b>4,136,866.4</b>	<b>1,260,746.9</b>

Дээрх хүснэгтээс харахад:Тайлант онд авлага дансны эцсийн үлдэгдэл 33,744.0 мянган төгрөг, НДШ-ийн илүү төлсөн авлага 2,486.5 мянган төгрөг, ЗДТГ-ын тракторын агрегатын эхний төлбөр шилжүүлснээс нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 71,526.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 105,106.9 мянган төгрөгөөр буюу 33,580.3 мянган төгрөгөөр аж ахуйн материал, өвс, тэжээл худалдан авснаас нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,804,592.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 4,136,866.4 мянган төгрөг болж, 1,260,746.9 мянган төгрөгөөр худалдан авсан хөрөнгө болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/15 тоот тушаалаар 9,124.4 мянган төгрөг, 2023 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/19 тоот тушаалаар 33,890.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 78,316.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 198,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 47,214.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 16,960.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,000.0 мянган төгрөгийн зам гүүрний байгууламж, 27,925.0 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 3,000.0 мянган төгрөгийн ном, 615,968.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 1,750.0 мянган төгрөгийн программ хангамж, 90,685.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө, орон нутгийн хөгжийн сангийн хөрөнгөөр үнэ төлбөргүй 79,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 16,484.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 13,810.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 23,738.3 мянган төгрөгийн зам гүүрний байгууламж, 340,630.3 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 4,653.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 4,000.0 мянган

төгрөг буюу 653.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,132,866.4 мянган төгрөг болж 1,261,400.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 611,245.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 1,192,796.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны зардлыг 1,442,386.3 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардалд 361,655.7 мянган төгрөгөөр нийт 1,804,042.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь байгаль орчныг нөхөн сэргээх зардалд 884,722.5 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардал 361,655.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг Төв аймгийн Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 02 дугаар тогтоолоор, 206,747.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2,010,789.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,010,789.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үндсэн үйл ажиллагааны орлого 17,882.9 мянган төгрөг, баг хорооны үйл ажиллагааны зардал 494.2 мянган төгрөг, бусад зардлаас 78,212.3 мянган төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгийн зардал 1,548.0 мянган төгрөг, байгаль орчны нөхөн сэргээх зардал 86,773.6 мянган төгрөг нийт 184,911.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,825,878.5 мянган төгрөг буюу 90,8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 106,698.8 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 78,212.3 мянган төгрөгөөр буюу цалин, НДШ 1,283.1 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 10,293.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 507.0 мянган төгрөг, эд хогшлын зардал 7.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 6,286.4 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардал 88,321.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 78,212.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	539,308.4	521,485.5	17,822.9	96.7

2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	4,983.5	4,489.3	494.2	90.1
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны үйл ажиллагааны зардал	25,390.0	25,390.0	0.0	100.0
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардал	543,384.6	465,172.3	78,212.3	85.6
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-бусад хөрөнгийн зардал	5,000.0	3,452.0	1,548.0	69.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	5,000.0	0.0	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын их баяр наадмын зардал	884,722.5	797,948.9	86,773.6	90.2
8	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	3,000.0	3,000.0	0.0	100.0
	<b>Дүн</b>	<b>2,010,789.0</b>	<b>1,825,938.0</b>	<b>184,851.0</b>	<b>90.8</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд урьд оны санхүүжилтээс 31,783.7 мянган төгрөг, цас зудын гамшигт хандиваар шатахуун 2,000.0 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 36,018.0 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого, судалгааны зардалд 1,760.2 мянган төгрөг, гэр хорооллын айл өрхийн дулааны шугамын холболтын санхүүжилт 79,954.0 мянган төгрөг, хивэг тэжээлийн мөнгө 24,655.3 мянган төгрөг, усны үнэ 11,876.6 мянган төгрөг, хөдөлмөр зуслан байгуулах ажлын оролцооны санхүүжилт 27,925.0 мянган төгрөг, үнэт цаасны орлого 1,076.5 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэг 5,000.0 мянган төгрөг, бусад 4,540.0 мянган төгрөг, цахим тендерийн үнэ 1,260.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг 87,614.3 мянган төгрөг нийт 315,464.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд дансанд урьд оны санхүүжилтээс 31,352.3 мянган төгрөг, цас зудын гамшигт хандиваар шатахуун 1,278.8 мянган төгрөг, орон нутгийн нэмэгдэлд 13,843.2 мянган төгрөг, хагас жилийн мал тооллого, судалгааны зардалд 1,760.2 мянган төгрөг, гэр хорооллын айл өрхийн дулааны шугамын холболтын санхүүжилт 79,954.0 мянган төгрөг, хивэг тэжээлийн мөнгө 16,137.7 мянган төгрөг, усны үнэ 11,153.4 мянган төгрөг, хөдөлмөр зуслан байгуулах ажлын оролцооны санхүүжилт 27,925.0 мянган төгрөг, үнэт цаасны орлого 539.9 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэг 5,000.0 мянган төгрөг, бусад 4,540.0 мянган төгрөг, цахим тендерийн үнэ 1,100.0 мянган төгрөг, сумын төвийн гэрэлтүүлэг 87,614.3 мянган төгрөг нийт 282,198.8 мянган төгрөг зарцуулж 33,265.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 91,2%	1,123,066.5	1,024,989.1
2	71411- Хүрээлэн буй, орчны бодлого удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй, орчны бодлого удирдлага хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 90,2%	887,722.5	800,948.9
<b>Дүн</b>					<b>2,010,789.0</b>	<b>1,825,938.0</b>

**3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Мөнгөнморьт сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 507,094.5 мянган төгрөгөөр 46 нэр төрлийн тоног төхөөрөмж, бараа ажил үйлчилгээг шууд худалдан авалтаар, ерөнхий гэрээгээр 35,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,389,635.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг цахим тендер зарлан худалдан авахаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 71,085.0 мянган төгрөгийн хөрөнгийг шууд худалдан авалтаар, цахим дэлгүүрээс ерөнхий гэрээгээр 33,865.0 мянган төгрөгийг тоног төхөөрөмж, 807,171.6 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг тендер зарлаж худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шатахууны тооцоо бодолтой холбоотой зөвлөмж өгсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын ИТХ-аас баталсан 2023 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын ИТХ-аас батлагдсан 2023 оны төсвийн 1,482,405.0 мянган төгрөгийн нийт зардлаас 1,0 хувиар буюу 14,824.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,376.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100%-тай, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл 14, 5,0 саяас дээших орлогын 21 гүйлгээ, зарлагын 55 гүйлгээг мэдээлснээс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл 13 байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төрийн хэмнэлттэй холбоотой 2 төлбөрийн акт, шилэн данстай холбоотой 1 зөвлөмжийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 06/35 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	14,985.9	2	14,985.9	100
Албан шаардлага					
Зөвлөмж	1	633,917.8	1	633,917.8	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>648,903.7</b>	<b>3</b>	<b>648,903.7</b>	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 2,736.5 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 2,736.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

1. Тус байгууллага тайлант оны санхүүгийн байдлын нийт хөрөнгө, өр төлбөр цэвэр өмчийн дүн 250.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тус байгууллага тайлант онд санхүүгийн тайланд НДШ-ийн илүү төлөлт 2,486.5 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 135,350.8 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 9,593.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 112,407.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 13,349.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Төлбөрийн акт

1. Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Мөнгөнморьт сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн “Зарим төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай ” Б/02 тоот захирамжаар Улс төрийн 5 албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 9,593.5 мянган төгрөг олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Монгол Улсын Засгийн

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

• Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

1. Тус байгууллага тайлант онд хөрөнгийн зардлаас бараа материалын зардалд 112,407.6 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Монгол улсын Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал батлах зааврын Хөрөнгийн зардлын “Тухайн төсвийн жилд төсвийн хөрөнгөөр үл хөдөл хөрөнгө бий болгох, барилга, байгууламж, тоног төхөөрөмж худалдан авах, барилга байгууламжид их засвар хийх, стратегийн бараа бүтээгдэхүүнийг улсын нөөцөд байршуулахтай холбоотой зарцуулах зардлууд энд багтана” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

• Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

## **5.4 Зөвлөмж**

### 1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Тус байгууллага тайлант онд аж ахуй нэгж байгууллагаас 13,349.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус худалдан авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-т “Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалтыг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цахим дэлгүүрийн бараанаас худалдан авалт хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	НДШ-ийн илүү төлөлт авлагаар тусгаагүй тайлагнасан байна	1	2,486.5	1	2,486.5			1
санхүүгийн байдлын нийт хөрөнгө, өр төлбөр цэвэр өмчийн дүн зөрүүтэй тайлагнасан	1	250.0			1	250.0	1	250.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>2,736.5</b>	<b>1</b>	<b>2,486.5</b>	<b>1</b>	<b>250.0</b>	<b>1</b>	<b>2,736.5</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд хөрөнгийн зардлаас урсгал зардалд 112,407.6 мянган төгрөг зарцуулсан байна.	1	112,407.6			1	112,407.6		
Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамжаар Улс төрийн 5 албан хаагчийн орон нутгийн нэмэгдлийг төсөвтөө багтаан шийдвэрлэх гэсэн дагуу нэмэгдэлд олгосон зөрчил илэрлээ	1	9,593.5	1	9,593.5				
Аж ахуй нэгж байгууллагаас тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус тус худалдан авсан байна	1	13,349.7					1	13,349.7
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>135,350.8</b>	<b>1</b>	<b>9,593.5</b>	<b>1</b>	<b>112,407.6</b>	<b>1</b>	<b>13,349.7</b>

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)